



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 54

Мандалговь

Хөрөнгө дахин үнэлж
худалдах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6.3.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Биеийн тамир, спортын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 89-62 ДУА улсын дугаартай 8,140,500 /найман сая нэг зуун дөчин мянга таван зуун/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн УАЗ-31512 маркын автомашины худалдах доод үнийг 750,000 /долоон зуун тавин мянган/ төгрөг, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 09 дүгээр тогтоолоор балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн боловч орон нутгийн өмчид бүртгэлгүй явж ирсэн 39-28 ДУА улсын дугаартай УАЗ-31519 маркын автомашины худалдах доод үнийг 900,000 /есөн зуун мянган/ төгрөг, Луус сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 85,659,500 /наян таван сая зургаан зуун тавин есөн мянга таван зуун/ төгрөгийн анхны өртөгтэй, 57,306,205 /тавин долоон сая гурван зуун зургаан мянга хоёр зуун таван/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй цэцэрлэгийн барилгыг барилгын худалдах доод үнийг 6,250,000 /зургаан сая хоёр зуун тавин мянга/ төгрөгөөр тус тус тогтоон худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Эд хөрөнгийг хууль журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогоос 39-28 ДУА улсын дугаартай УАЗ-31519 маркын автомашины татварын тооцоог барагдуулж үлдэгдлийг, бусад хөрөнгөөс орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

0100130

42

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Биеийн тамир, спортын газар /М.Наранбадрах/, Луус сумын Цэцэрлэг /Л.Цогзолмаа/-т тус тус даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХТ-ийн 2017 оны 07 сарын 17-ны өдрийн 46 дугаар тогтоолын 2 дахь заалт, 2017 оны 07 сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын Луус сумын цэцэрлэгт холбогдох заалтуудыг тус тус хүчингүй болгосугай

5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

